

Сарын мэдээний дүгнэлт

АНЭ-ийн хэмжээнд 2025 оны 01 сарын байдлаар 87 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

Нийт амьд төрсөн 86 хүүхдийн 4 тохиолдол буюу /4.6%/ -нь 2500 граммаас доош жинтэй төрсөн байна. Нийт төрөлтийн 34.4%-нь жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлтэй төрсөн ба нийт хүндрэлийн 53.3%-нь жирэмсэн үеийн хүндрэл байна.

Нас баралт

2025 оны 01 сарын байдлаар АНЭ-т нас баралтын 4 тохиолдол бүртгэгдсэн.

Өвчний учир: Нийт – 4

1. Зүрхний архаг ишемит өвчин, тодорхойгүй (I25.9) – 1
2. Элэг ба элгэн дэх цэсний сувгийн өмөн (C22) - 1
3. Улаан хоолойн өмөн (C15) – 1
4. Бусад вирүст пневмони (J12.8) – 1

Амбулатори, стационарын тусламж үйлчилгээ

АНЭ-т 01 сард стационарт 1092 үйлчлүүлэгч эмчлэгдэж гарсан ба ор хоног 7296 байна. Дундаж ор хоног 6.7 байна.

2024 оны 01 сард 102 мэс заслын хагалгаа хийгдсэний 5 тохиолдол нь эмэгтэйчүүдийн хагалгаа бүртгэгдсэн байна.

Нийт 13067 үзлэг хийгдсэний 10.6% нь урьдчилан сэргийлэх үзлэг, 8.2% нь идэвхтэй үзлэг хийгдсэн байна. Амбулаториор 3745 өвчлөл бүртгэгдсэн байна.

Нийт түргэн тусламжийн 554 дуудлага хүлээн авч гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 30 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Нийт дуудлагын 5.2% нь алсын дуудлага байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эмгэг судлалын шинжилгээ 1 хийгдсэн. Эдийн шинжилгээ 58 тохиолдолд, эсийн шинжилгээ 544 тохиолдолд хийгдсэн.

Халдварт өвчин

АНЭ-т 2025 оны эхний 01 сарын байдлаар нийт 37 халдварт өвчин бүртгэгдсэн нь 10000 хүн амд 5.6%-тай байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс 0.9%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Халдварт өвчнийг бүтцээр нь авч үзвэл 21.6%-нь хурц халдварт өвчин, 16.2%-нь сүрьеэ 62.1%-нь БЗХӨ тус тус эзэлж байна.

Мэдээ хянасан: АНЭДарга:

Д.Алтантуяа

Мэдээ нэгтгэсэн: Статистикийн алба